



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/263

Булган сум

Мал, амьтны сэг зэмийг цуглуулж, устгах,
ариутгал, халдваргүйтгэлийн ажил зохион
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.3 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, ерөнхий малын эмчийн 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/73 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын хүндрэлээс үхэж хорогдсон мал, амьтны сэг, зэмийг устгах, бэлчээр, хашаа хороо, өвөлжөө, хаваржаа болон худаг, уст цэгийн орчныг цэвэрлэж ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 01-ний хугацаанд зохион байгуулсугай.

2. Дээрх ажилд мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т, хүн хүч, машин техник, бусад шаардлагатай зүйлсээр хангаж, малчид, багийн дарга нарыг үүрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР